



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/61


Улаанбаатар хот

“Эрүүл ажлын байр танаас эхэлнэ” сэдэвт сургалт семинарыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргааны, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагын биеийн тамир, спортын хамтлагийн арга зүйчдийн дундах “Эрүүл ажлын байр танаас эхэлнэ” сургалт семинарыг 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдөр “Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн” ТББ-ын хурлын зааланд зохион байгуулсугай.
2. Сургалт семинарт зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Сургалт семинарыг зохион байгуулахад шаардагдах 580.000 /Таван зуун наян мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны сургалт, семинарын зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.
4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн /Б.Түвшинбаяр /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын
2017 оны *10-дугаар* сарын *18*-ны өдрийн
А.Б. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Сургалт семинарыг зохион
байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Багшийн ажлын мөнгө: 1 хоног х 6 цаг х 30.000 төг	180.000
2.	Заал талбайн зардал	100.000
3.	Бичиг хэргийн зардал	100.000
4.	Гарын авлага сурталчилгаа	200.000
ДҮН:		580.000

Боловсруулсан: *Б.Түвшинбаяр*
Хянасан : *О.Эрдэнэцэцэг*

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын
2017 оны 10 сарын 18-ны өдрийн
А.С. дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Сургалт, семинарт хичээл
заах багш нарын бүрэлдэхүүн

- | | |
|-------------------|---------------------------------------------------------------------------------|
| 1. Б.Золжаргал | МУИС-ийн сэтгэл судлалын багш, хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэнгийн захирал |
| 2. Х.Мөнхзул | Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн, сэтгэл судлаач |
| 3. Т.Халиун | Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн, сургагч багш |
| 4. Б.Номин | Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн, сэтгэл судлаач |
| 5. С.Пүрэв-Эрдэнэ | Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн, сэтгэл судлаач |
| 6. М.Мөнхжаргал | Хүний хөгжлийн зөвлөх, Төрийн удирдлагын магистр |